Барилгын хөгжлийн төвийн захирлын тушаал
Дугаар.....
Хавсралт 1

Барилгын хөгжлийн төв
Барилга, байгууламжийн зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл хэсгийн нэр **/Гадна ус хангамж, ариутгах татуурга:/**
Соёлын төвийн гадна тохижилт, гадна шугам сүлжээний ажлын зураг төсөл, төсөв

2023 оны 08 сарын 09 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Барилга байгууламжийн нэр	Соёлын төвийн гадна тохижилт, гадна шугам сүлжээний ажлын зураг төсөл, төсөв
2	Барилга байгууламжийн байршил, хүчин чадал	Дундговь аймаг, Цагаандэлгэр сум, 1-р баг
3	Зураг төслийн байгууллага	"Өлзий-Иш" ХХК
4	Зургийн шифр	ӨИ-19-19/2023Ө
5	Хуудасны тоо	УХАТ-1-7 УХАТ-6 хуудас ирүүлээгүй инженер В.Анхзаяа, шалгасан мөн В.Анхзаяа
6. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоос/		
1	6.12.1. архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зураг, эх загвар зураг/эскиз/, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүдийг тодорхойлсон, техникийн нөхцөлтэй эсэх;	Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Засаг даргын 2023.05.12-ны өдрийн 01/96, 01/97 тоот албан бичиг
2	6.12.2. холбогдох мэргэжлийн байгууллагаар энэ дүрмийн 5.2-т заасны дагуу хянуулж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан эсэх;	Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Засаг дарга А.Эрдэнэсайхан зөвшөөрсөн. Галын аюулгүй байдал, орчны эрүүл ахуйг хангасан эсэх талаар холбогдох байгуулагуудын дүгнэлт гаргуулсан эсэх нь тодорхойгүй тул виз авах /Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолд заасан/
3	6.12.3. барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, барилга бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь норм, нормативын баримт бичиг, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцлийн дагуу боловсруулсан эсэх;	БНбД 40-0216,БНбД 40-04-16, БД 40-102-06 болон MNS 6279-2011-ын дагуу боловсруулсан эсэх нь тодорхойгүй, нэмэх Усны зардалын тооцоог хийж, гидравлик тооцооны дагуу шугамын диаметр, налуу шалгаж үзэх. Ус хэрэглээний хэтийн тооцоолол хийхдээ БОНХАЖС-ын 2015 оны А/301 дүгээр тушаал, ЭМС, БОАЖС-ын 2017 оны А-333/А-245 дугаар хамтарсан тушаал, БХБС-ын 2016 оны 116 дугаар тушаалын альнийг хэрэглэсэнийг тайлбарт тодорхой бичих. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн "17.4.1.хот, суурины төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн /худаг/ эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүй зайд;"-д тогтоохоор заасан тул хамгаалалтын бүсийн талаар тайлбар нэмэх, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн "17.6.Төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугамын тэнхлэгээс хоёр тийш таван метрт хамгаалалтын зурвас тогтооно.", мөн хуулийн17.14.Бохир ус татан зайлуулах шугамын тэнхлэгээс хоёр тийш зургаан метрээс багагүй зайд барилга байгууламж, шугам сүлжээг барихыг хориглоно. гэснийг хангуулаагүй байна./зурагт зурж үзүүлэх/ нэмж бичих, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11.1.4.энэ хуулийн 11.1.3-т заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэх УХАТ-1 хуудасны /Топаэро г.м/, УХАТ-4 хуудаст /WILO/ анхаарах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан /11.1.3.барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөл тавихгүй; 11.1.4.энэ хуулийн 11.1.3-т заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэх./ гэсэн тул Топаэро, WILO гэдэг үгийг хасах. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18.1.Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө боловсруулах, шинэчлэх, өөрчлөх, барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, ашиглах, үйлдвэрийн технологийн горимыг өөрчлөхөд холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийг мөрдөнө. гэж заасан Галын машинтай байх эсэх? Галын гидрантыг төлөвлөх эсэх?. Одоо байгаа гүний Ембүү худагны ундарга, насосны үзүүлэлтийг бичиж, худгийн барилга дотор ямар холболт хийхийг зурж үзүүлэх

Д/д	Утга	Тайлбар
4	6.12.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;	Барилгын тухай хуулийн Зураг төсөл зохиогчийн чиг үүрэг 38.1.7.энэ хуулийн 16.3-т заасан зураг төслийг боловсруулах; / барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл боловсруулна./ гэж заасныг анхаарах
5	6.12.5. барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх;	Барилгын тухай хуулийн "16.3.Барилга байгууламжийн угсралт, буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл боловсруулна. 40.1.13.барилгын ажил гүйцэтгэх технологи, үйлдвэрлэл, техникийн ослоос сэргийлсэн хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээний зохион байгуулалтын зургийг боловсруулж, түүний дагуу гүйцэтгэх"-ийг гүйцэтгэгчид сануулан тайлбар бичих.
6	6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;	Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргаагүй. Дулаалгатай хоолойн үзүүлэлтийг тооцсон дулаан техникийн тооцоо байхгүй.
7	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангуулсан эсэх;	
8	6.12.8. эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	ямар нэг тайлбар тооцоо, мэдээлэл ирүүлээгүй
9	6.12.9. зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх.	" Бага оврын цэвэрлэх байгууламж төлөвлөв" гэсэн боловч холбогдох тооцоо, зураг төсөл, мэдээлэл байхгүй байна. Дээр дурдсан зөвлөмжүүдийг зураг төсөлд тусган албажуулах

Дүгнэлт бичсэн

Эксперт № 6-8 Б.Бямбажав /...../

2023 оны 08 сарын 09 өдөр